



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 8/24

Арвайхээр сум


**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өсвөрийн шатарчдын 2024 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардал болон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх 4,480,000 (дөрвөн сая дөрвөн зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0047

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр  
сарын 22 -ны өдрийн 1/24 дугаар  
захирамжийн хавсралт

ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН 2024 ОНЫ АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭНИЙ БОЛОН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД  
ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН ЗАРДАЛ

№	Юунд	Тоо ширхэг	Нэг бүр	Нийт
1.	Медаль	42	10.000	420.000
2.	Өргөмжлөл	70	3000	210,000
3.	Шүүгчийн зардал	5 хүн	160,000	800,000
4.	Аннос хэвлүүлэх	4*6=24т/кв	6,250	150,000
5.	Улаанбаатар хотод улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын замын зардал	20 хүн	45,000	900,000
6.	Улаанбаатар хотод улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын байрлах байрны зардал	20 ор	50,000	1,000,000
7.	Улаанбаатар хотод улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын хоолны зардал	20 хүн 2 өдөр	50,000	1,000,000
Нийт зардал				4,480,000

-oOo-